**Техникийн тодорхойлолт**

Нийлүүлэх бараа нь доор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн байна.

**Багц № 1: Зорчигчийн үйлчилгээний хийжүүлсэн ундаа**

| Д/д | Барааны нэр | Тодорхойлолт |
|---|---|---|
| 1 | ***Хийжүүлсэн ундаа*** | **Зориулалт:** Нислэгийн үеийн хүйтэн ундааны үйлчилгээнд зориулагдсан, Кола /light, zero/, Фанта, Спрайт гэсэн 4 төрөл байна.<br><br>**Хадгалалт, тээвэрлэлт**<br>- Хуванцар болон металь лонхонд савласан бүтээгдэхүүнийг /5-10 градус цельс/ агаарын харьцангуй чийгшил 75%-иас ихгүй нөхцөлд 12 сар хүртэл хугацаагаар нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалж хадгалсан байх.<br>- Хуванцар сав нүүрсхүчлийн хийн агууламжаа амархан алддаг тул энэ төрлийн савтай 1л-ээс дээш ээлхүүнтэй бол 12 сар хүртэл хугацаагаар хадгалах зориулалттай байх.<br>- Чанар, ариун цэврийн шаардлага хангасан агуулахад хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх.<br><br>**Ерөнхий шаардлага, үзүүлэлт**<br>- Монгол улсын MNS 0687-3:2015 стандарт болон бэлтгэн нийлүүлэгч орны стандартын шаардлагыг хангасан байх.<br>**Савлагаа шошгололт**<br>- Савласан хийжүүлсэн ундаа нь MNSCAC1:2007 , MNSCACGL2:2007 стандартын шаардлагыг хангасан шошготой байх.<br>- Хийжүүлсэн ундаа, ус нь Бизнес ангилалд металиар хийгдсэн 200-330 мл-ийн лаазанд, энгийн ангилалд 1.25л хуванцар лонхонд савласан байна.<br>**Төрөл:**<br>Нийт коланы /light 25%, zero 25%/, фанта, спрайт байна.<br><br>**Холбогдох сертификат:**<br>❖ Бүтээгдэхүүний Гарал үүслийн гэрчилгээ<br>❖ Тохирлын гэрчилгээ эсхүл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ.<br>*Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу төрөл тус бүр дээр загвар дээж ирүүлнэ. |
| 2 | ***Тоник*** | **Савлагаа, шошгололт:**<br>Тоник нь 200 мл хэмжээтэй шингэн хүнсний зориулалтын металь лаазанд савлагдсан байна.<br>Савласан бүтээгдэхүүний шошгололтод тавигдах шаардлага хангасан шошготой байх. Шошгон дээр бүтээгдэхүүний онцлох |

| | | |
|---|---|---|
| | | шинж чанар, хэрэглэх заавар, үзэсгэлэн яармагаас авсан чанарын тэмдэг, үндэсний тохирлын тэмдэг зэргийг тусгасан байна.<br>**Хадгалалт, тээвэрлэлт:**<br>Нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан, 5-20 градусын температуртай нөхцөлд эрдэслэг усыг 1 жил хүртэл, нэмэлттэй усыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалах зориулалттай байна.<br>**Ерөнхий шаардлага, үзүүлэлт:** Тоник нь байгалийн гүний, гадаргын болон төвлөрсөн усан хангамжаас эх үүсвэртэй, батлагдсан технологийн зааврын дагуу боловсруулалт хийж, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчмыг баримтлан үйлдвэрлэсэн, шууд ууж хэрэглэх зориулалттай байна.<br>**Холбогдох сертификат:**<br>❖ Бүтээгдэхүүний Гарал үүслийн гэрчилгээ<br>❖ Тохирлын гэрчилгээ эсхүл Үндэсний итгэмжлэлийн төвийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг ирүүлнэ.<br>*Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу загвар дээж ирүүлнэ. |

***Багц № 3: Зорчигчийн үйлчилгээний цэвэр ус***

| **Д/д** | **Барааны нэр** | **Тодорхойлолт** |
|---|---|---|
| **1** | ***Цэвэр ус*** | **Төрөл:** 0,33 л, 1,5 л гэсэн 2 төрөл байх ба тус бүр хуванцар лонхонд савлагдсан байна.<br>**Савлагаа, шошгололт**:<br>Цэвэр ус нь нийлэг хуванцар лонхонд савлагдсан байх ба хуванцар савны хэрэглэсэн түүхий эд нь Монгол улсын болон олон улс, бэлтгэн нийлүүлэгч орны стандартын шаардлагыг хангасан байна.<br>Савласан бүтээгдэхүүний шошгололтод тавигдах MNSCAC4280:95 стандартын шаардлага хангасан шошготой байх. Шошгон дээр бүтээгдэхүүний онцлох шинж чанар, хэрэглэх заавар, үзэсгэлэн яармагаас авсан чанарын тэмдэг, үндэсний тохирлын тэмдэг зэргийг тусгасан байна.<br>Цэвэр ус нь доорх шаардлагыг хангасан эрдэсжүүлсэн ус байна.<br>НАТРИ+КАЛИ Na K 31.1<br>Кальци (Ca) 40.0-66.0<br>Магни (Mg) 7.3-12.0<br>Хлор (Cl) 14.2<br>Гидрокарбонат (HCO3) 207<br>Сульфат (SO4) 25.0-60.1<br><br>**Хадгалалт, тээвэрлэлт:**<br>Нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан, 5-20 градусын температуртай нөхцөлд эрдэслэг усыг 1 жил хүртэл, нэмэлттэй усыг 6 сар хүртэл хугацаагаар хадгалах зориулалттай байна. |

| | | |
|---|---|---|
| | | **Ерөнхий шаардлага, үзүүлэлт:** Цэвэр ус нь Монгол улсын MNS5007-2007 стандартын шаардлага хангасан байна.<br>*Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу төрөл тус бүр дээр загвар дээж ирүүлнэ. |
| **2** | ***Хийжүүлсэн ус*** | Цэвэр усанд тавигдах шаардлагыг хангасан хийжүүлсэн ус байна. Бизнес болон энгийн ангиллын үйлчилгээнд зориулагдсан.<br>Бизнес ангилалд 330гр-ын шилэн лонхонд, энгийн ангилалд 200гр-330гр-ын шингэн хүнсний зориулалтын хуванцар болон металь лонхонд савласан байна.<br>*Техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу төрөл тус бүр дээр загвар дээж ирүүлнэ. |